



БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Сэндли ББСБ” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр
тасалбар болгосон санхүүгийн тайлан

АГУУЛГА

Хуудас

Удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Хараат бус Аудиторын тайлан

1-4

Аудитлагдсан санхүүгийн тайлан

Санхүүгийн байдлын тайлан

5

Орлогын дэлгэрэнгүй тайлан

6

Өмчийн өөрчлөлтийн тайлан

7

Мөнгөн гүйлгээний тайлан

8-9

Санхүүгийн тайлангийн тодруулга

Тайлагнагч компанийн талаар

10-11

Аудиторын талаарх мэдээлэл

11

Тайлан бэлтгэсэн үндэслэл

12-14

Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шүүн тунгаалт

15-16

Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

17-27

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

28-46

Эрсдэлийн удирдлага

47-55

Капиталын удирдлага

56-57

Болзошгүй зүйл

58

Балансын дараах үйл явдал

58

Зэрэгцүүлсэн мэдээлэл

58

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“СЭНДЛИ ББСБ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Дүгнэлт

Бид 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Сэндли ББСБ” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Сэндли ББСБ” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (Хараат бус байдлын олон улсын стандартыг багтаасан)-н дагуу компаниас хараат бус байж, эдгээр ёс зүйн шаардлагууд, НБЁЗОУСЗ-ийн дүрэмд нийцсэн ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудал нь тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн чухал нөлөөтэй гэж бидний мэргэжлийн шийдлээр авч үзсэн асуудлууд болно. Аудитын эдгээр гол асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудитын дүгнэлтээ илэрхийлэхдээ бүхэлд нь авч үзсэн бөгөөд эдгээр гол асуудлуудын талаар тусад нь дүгнэлт илэрхийлэхгүй.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
(үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд

Зээлийн үнэ цэнийн бууралт

Удирдлага нь хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн харилцагчдад олгосон зээл болон бусад авлагын үнэ цэнийн бууралтыг тооцохдоо үнэлэмж болон өндөр түвшний төсөөлөл ашиглан тооцоолдог тул бид уг асуудлыг аудитын гол асуудлаар тодорхойлсон.

Компани 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар санхүүгийн тайланд 109,754,700 мянган төгрөгийн харилцагчдад олгосон зээл болон бусад авлагын үлдэгдэл толилуулсан.

Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлого болон нягтлан бодох бүртгэлийн гол тооцооллууд болон үнэлэмжүүдийг санхүүгийн тайлангийн Тодруулга 4 болон 5-г толилуулсан.

Харилцагчдад олгосон зээл болон бусад авлага мөн тэдгээртэй холбогдох зээлийн эрсдэлийн удирдлагын тодруулгуудыг санхүүгийн тайлангийн Тодруулга 6.2, 6.4, 6.30-д тус тус толилуулсан.

Бусад асуудал

Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн аудитыг Хүлэгтхүннү Аудит ХХК хийж гүйцэтгэж, өөрчлөлтгүй дүгнэлт илэрхийлсэн.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болох ба бид бусад мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Бидний гүйцэтгэсэн аудитын горим

Бид удирдлагын тооцооллын арга нь зохистой эсэхийг дараах байдлаар авч үзсэн:

- Үнэ цэнийн бууралтын санг тооцоолох аргачлалыг үнэлэхдээ бид компанийн ашиглаж буй холбогдох төсөөлөл, түүний үндэслэлийн талаар дэлгэрэнгүй ойлголт авч, загварын зохистой байдлыг үнэлсэн.
- Бид тооцоололд ашигласан мэдээллийн үнэн зөв болон бүрэн байдлыг түүвэрлэн шалгасан бөгөөд үнэ цэнийн бууралтын тооцоололд ашигласан үнэлэмжийн тууштай байдлыг авч үзсэн.
- Бид тооцооллын үнэн зөв байдлыг шалгахын тулд дахин тооцоолол хийсэн бөгөөд санхүүгийн тайланд холбогдох тодруулгуудыг хангалттай, зохистой хэмжээнд толилуулсан эсэхийг мөн үнэлсэн.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН **(үргэлжлэл)**

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Гэхдээ алдаанаас бус компанийн үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- ✓ Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага (үргэлжлэл)

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бусад

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн бөгөөд бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Ц.ЖИГДЭН, ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР
БЭЙКЕР ТӨЛӨН ДАЛГАВАН АУДИТ ХХК



2026 ОНЫ 02 ДУГААР
САРЫН 11-НИЙ ӨДӨР

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

		Төгрөгөөр	
ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	2025.12.31	2024.12.31
ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6.1	13,655,550,392	16,615,611,045
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	6.2	108,939,423,816	80,798,949,840
Факторингийн тооцооны авлага	6.3	28,256,156	28,256,156
Бусад санхүүгийн хөрөнгө	6.4	815,276,558	1,185,093,342
Санхүүгийн хөрөнгийн дүн		123,438,506,922	98,627,910,383
Бараа материал, үнэ бүхий зүйл	6.9	236,865,841	117,752,800
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	6.10	394,079,627	685,876,069
Өмчлөх бусад хөрөнгө	6.11	26,966,710	
Хойшлогдсон татварын хөрөнгө	6.17		11,821,123
Үндсэн хөрөнгө	6.12	352,785,870	181,752,875
Биет бус хөрөнгө	6.13	662,250,626	554,568,105
Ашиглах эрх бүхий хөрөнгө	6.15	229,933,002	22,750,353
Санхүүгийн бус хөрөнгийн дүн		1,902,881,676	1,574,521,325
Нийт хөрөнгийн дүн		125,341,388,598	100,202,431,708
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Өр төлбөр			
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	6.5	31,045,749,137	27,331,033,399
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	6.6	23,278,072,054	21,222,709,033
Бусад эх үүсвэр	6.7	15,074,373,196	15,275,901,370
Хоёрдогч өглөг	6.8	10,980,038,247	
Санхүүгийн өр төлбөрийн дүн		80,378,232,634	63,829,643,802
Татвар, НДШ-ийн өр төлбөр	6.14	1,601,588,707	1,076,301,747
Хойшлогдсон татварын өр төлбөр	6.17	90,528,000	
Бусад санхүүгийн бус өр төлбөр	6.15, 6.16	770,621,836	1,178,997,748
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн		2,462,738,543	2,255,299,495
Нийт өр төлбөрийн дүн		82,840,971,177	66,084,943,297
Өөрийн хөрөнгө			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	6.18	11,178,500,000	11,178,500,000
Нэмж төлөгдсөн капитал		6,284,799,653	6,284,799,653
Хуримтлагдсан ашиг, алдагдал		24,096,224,529	16,641,246,354
Бусад өмч	6.19	940,893,239	12,942,404
Өөрийн хөрөнгийн дүн		42,500,417,421	34,117,488,411
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн		125,341,388,598	100,202,431,708

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

		Төгрөгөөр	
ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	2025.12.31	2024.12.31
Хүүгийн орлого	6.20		
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн хүүгийн орлого		121,350,139	48,691,990
Зээлийн хүүгийн орлого		33,702,242,143	22,489,830,545
Хүүгийн зардал	6.20		
Итгэлцлийн хүүгийн зардал		(4,860,098,669)	(3,832,014,349)
Зээлийн хүүгийн зардал		(4,554,915,553)	(1,731,933,494)
Бусад хүүгийн зардал		(3,642,871,044)	(1,707,989,041)
Хүүгийн цэвэр орлого		20,765,707,016	15,266,585,651
Эрсдэлийн сангийн зардал	6.2, 6.4	(2,656,627,179)	(1,108,312,839)
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого		18,109,079,837	14,158,272,812
Хүүгийн бус орлого			
Арилжааны орлого	6.21	735,093,813	118,375,334
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	6.22	2,865,644,935	275,829,500
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	6.23	4,238,545,730	4,746,661,650
Бусад хүүгийн бус орлого	6.24	400,168	34,001,451
Хүүгийн бус зардал			
Арилжааны зардал	6.21	(266,775,260)	(60,981,123)
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	6.22	(3,353,561,481)	(331,200,284)
Хураамж, шимтгэлийн зардал	6.23	(2,429,443,745)	(2,191,068,601)
Үйл ажиллагааны бусад зардал	6.25	(7,948,312,749)	(6,393,226,938)
Бусад зардал, гарз	6.26	(393,453,908)	(220,036,917)
<i>Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал</i>		<i>11,557,217,340</i>	<i>10,136,626,884</i>
Орлогын татварын зардал	6.27	(2,132,514,051)	(1,634,156,721)
<i>Татварын дараах ашиг, алдагдал</i>		<i>9,424,703,289</i>	<i>8,502,470,163</i>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг		=	=
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал		9,424,703,289	8,502,470,163
Бусад дэлгэрэнгүй орлого		=	=
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн		9,424,703,289	8,502,470,163
Нэгж хувьцаанд ногдох ашиг	6.28		
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг		42.16	38.03
Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг		37.48	38.03

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

“СЭНДЛИ ББСБ” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жил

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Бусад өмч	Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	Нийт дүн
2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	11,178,500,000	6,284,799,653	15,105,992	9,353,799,833	26,832,205,478
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(1,215,023,642)	(1,215,023,642)
Залруулсан үлдэгдэл	11,178,500,000	6,284,799,653	15,105,992	8,138,776,191	25,617,181,836
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				8,502,470,163	8,502,470,163
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт			(2,163,588)		(2,163,588)
Хуваарилсан ногдол ашиг					
2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	11,178,500,000	6,284,799,653	12,942,404	16,641,246,354	34,117,488,411
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				42,664,750	42,664,750
Залруулсан үлдэгдэл	11,178,500,000	6,284,799,653	12,942,404	16,683,911,104	34,160,153,161
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				9,424,703,289	9,424,703,289
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт			927,950,835	(311,022,164)	616,928,671
Хуваарилсан ногдол ашиг				(1,701,367,700)	(1,701,367,700)
2025 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	11,178,500,000	6,284,799,653	940,893,239	24,096,224,529	42,500,417,421

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Төгрөгөөр	
	2025.12.31	2024.12.31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн +/-	332,636,386,720	317,503,532,224
Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	260,067,118,907	259,245,194,439
Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	17,649,606,335	19,062,322,824
Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан хүлээн авсан	49,824,272,944	34,594,014,961
Бусад мөнгөн орлого	5,095,388,534	4,602,000,000
Мөнгөн зарлагын дүн +/-	(341,588,944,495)	(331,828,214,755)
Олгосон зээл	(256,886,521,181)	(271,065,016,339)
Буцаан олгосон итгэлцэл, үр шим	(19,129,274,162)	(16,314,572,384)
Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан буцаан шилжүүлсэн	(49,437,517,496)	(34,273,026,235)
Факторингийн үйл ажиллагаагаар шилжүүлсэн		(36,256,156)
Ажиллагсад олгосон	(4,175,260,597)	(3,697,649,952)
Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(4,140,455,567)	(2,176,369,466)
Ашиглалтын зардалд төлсөн	(38,137,628)	(29,702,548)
Бусад мөнгөн зарлага	(7,781,777,864)	(4,235,621,675)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(8,952,557,775)	(14,324,682,531)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн зарлагын дүн +/-	(449,296,753)	(67,285,900)
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(449,296,753)	(67,285,900)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(449,296,753)	(67,285,900)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн +/-	53,608,698,298	46,142,197,901
Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлээс хүлээн авсан	41,575,378,298	29,842,197,901
Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	12,033,320,000	
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		15,000,000,000
Бусад мөнгөн орлого		1,300,000,000

“СЭНДЛИ ББСБ” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жил

Мөнгөн зарлагын дүн /-/	(47,166,904,423)	(29,373,461,679)
Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлд төлсөн	(44,791,022,207)	(19,155,168,309)
Хоёрдогч өглөгт төлсөн	(674,514,524)	
Төлсөн ногдол ашиг	(1,701,367,692)	(1,251,992,000)
Бусад мөнгөн зарлага		(8,966,301,370)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,441,793,875	16,768,736,222
Валютын ханшийн зөрүү		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,960,060,653)	2,376,767,791
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,615,611,045	14,238,843,254
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,655,550,392	16,615,611,045

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

1. ТАЙЛАГНАГЧ КОМПАНИЙН ТАЛААР

“Сэндли ББСБ” Хувьцаат Компани (цаашид Компани гэх) нь Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагчдын 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн шийдвэрээр “Гялс Кредит ББСБ” Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. 2015 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж, 5961548 регистрийн дугаар бүхий 000264577 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан. “Гялс Кредит ББСБ” ХХК нь 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр оноосон нэрээ “Сэндли ББСБ” ХХК болгон өөрчилсөн.

Компани нь 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Монголын Хөрөнгийн биржид нийт 223,570,000 ширхэг энгийн хувьцаагаа олон нийтэд санал болгосноор Хувьцаат Компани болсон.

Компанид Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн №318 тоот тогтоолоор Зээлийн, 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн №62 тоот тогтоолоор Гадаад валютын арилжаа, Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний, 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн №441 тогтоолоор Факторинг, Итгэлцэл, Төлбөрийн баталгаа гаргах тусгай зөвшөөрлийг тус тус олгосон байна.

Компани нь дүрэм болон Улсын бүртгэлийн гэрчилгээ, Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тусгаснаар дараах үйл ажиллагааг эрхэлж байна. Үүнд:

- Зээлийн үйл ажиллагаа;
- Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;
- Гадаад валютын арилжаа;
- Факторингийн үйлчилгээ;
- Төлбөрийн баталгаа гаргах;
- Итгэлцлийн үйлчилгээ.

Гүйцэтгэх удирдлага:

Гүйцэтгэх захирал	Б.Одгэрэл
Үйл ажиллагаа хариуцсан захирал	Х.Ичинхорлоо
Санхүү хариуцсан захирал	Б.Номинзул
Бизнес хариуцсан захирал	П.Болорчулуун
Мөнгөн гуйвуулга хариуцсан захирал	Б.Нямжаргал
Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал	Д.Баярбат
Мэдээлэл технологи хариуцсан захирал	Н.Эрдэнэтулга
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан захирал	А.Итгэлт

Төлөөлөн удирдах зөвлөл:

ТУЗ-ийн дарга	Б.Наранбат
ТУЗ-ийн гишүүн	М.Цолмон
ТУЗ-ийн гишүүн	Н.Цэвэгмид
ТУЗ-ийн гишүүн	Н.Билгүүн
ТУЗ-ийн гишүүн	Б.Эрдэнэ
ТУЗ-ийн гишүүн	Л.Нарантуяа
Хараат бус ТУЗ-ийн гишүүн	Ч.Заяа
Хараат бус ТУЗ-ийн гишүүн	Б.Цэлмэг
Хараат бус ТУЗ-ийн гишүүн	Ц.Саруултуяа
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Б.Мөнхцэцэг

“СЭНДЛИ ББСБ” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жил

1. ТАЙЛАГНАГЧ КОМПАНИЙН ТАЛААР (үргэлжлэл)

Албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо
40,50 мянгат/15171/, Бакула Ренбүчи гудамж 8/4 тоот
Харилцах утас: 7017-7700
Веб хуудас: www.sendly.mn

2. АУДИТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Аудитын нэр: Бэйкер Тилли Далайван Аудит ХХК
Үйл ажиллагааны зөвшөөрөл: Аудит баталгаажуулалтын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 2025 оны 01 дүгээр сарын 28-ний өдрөөс 2029 оны 01 дүгээр сарын 28-ний өдөр хүртэл сунгуулсан.
Олон улсын гишүүнчлэл: 2007 онд аудит баталгаажуулалт болон зөвлөх үйлчилгээний олон улсын сүлжээ **Bakertilly International** байгууллагын хараат бус гишүүн байгууллагаар элссэн.
Албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо,
Амарсанаагийн гудамж, Компанийн өөрийн байр,
Харилцах утас: 7000-5401, 7000-5404,
Веб хуудас: www.btdalaivanaudit.mn

3. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

3.1 СТОУС-ын нийцэл

“Сэндли ББСБ” ХК-ийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ууд болон Санхүүгийн тайлагналын тайлбарын хороо (СТТХ)-оос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн. Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан СТОУС-ыг дагаж мөрдсөн болно.

Компанийн үйл ажиллагааны болоод тайлагнагч валют нь Монгол улсын Төгрөг байна. Эдгээр санхүүгийн тайлангууд нь төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

СТОУС-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг. Санхүүгийн тайлан бэлтгэхэд хийгдсэн нөлөө бүхий шийдэл ба тооцоолол, түүний нөлөөллийн талаар Санхүүгийн тайлангийн 4 дүгээр хэсэгт тодруулсан.

3.2 Хэмжилтийн үндэслэл

Эдгээр санхүүгийн тайлангууд нь өнөөгийн үнэ болон түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн. Өнөөгийн үнэ цэнийн суурь нь бодит үнэ цэн, ашиглалтын үнэ цэн болон одоогийн өртгөөр илэрхийлэгдсэн зүйлсийг агуулдаг бөгөөд санхүүгийн тайлангийн элементүүд тус бүрийн хэмжилтийн суурийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогоос харна уу.

3.3 Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Тасралтгүй байх зарчмын дагуу компани өөрийн бизнесийг төсөөлж болох ба ирээдүйн хугацаанд үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэсэн.

Хэрэв удирдлага компанийг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор санаархаж байгаа буюу эсвэл тэгэхээс өөр ямар ч бодит боломжгүй байхаас бусад тохиолдолд ерөнхий болон олон нийтийн зорилготой санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг.

Тасралтгүй байх таамаглалыг хэрэглэх нь зохимжтой бол тухайн байгууллага бизнесийн хэвийн явцад хөрөнгөө хэрэгжүүлж, өр төлбөрөө барагдуулах боломжтой байна гэсэн үндэслэлээр хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэдэг.

3. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ (үргэлжлэл)

3.4 Тайлангийн хугацаанд Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс батлагдаж шинээр хэрэгжиж эхэлсэн стандартууд болон бусад стандартын нэмэлт өөрчлөлтүүд.

СТОУС/НББОУС	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийн гол агуулга	Хэрэгжих огноо
НББОУС-21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө	Валют нь өөр валютаар арилжаалагдах боломжгүй нөхцөл байдал: НББОУС-21 "Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө"-д аж ахуйн нэгж нь тухайн валютын өөр бусад валютаар арилжаалагдах чадварыг үнэлэх болон тухайн валют нь өөр бусад валютаар арилжаалагдах чадваргүй тохиолдолд валютын ханшийг тооцоолохдоо тогтсон аргыг ашиглахыг шаардсан. Мөн холбоотой тодруулгаар хангах шаардлагыг тусгасан.	Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 8-р сард батлагдсан 2025 оны 1 сарын 1-ээс хойших хугацаанд хүчин төгөлдөр болно. Өмнө хэрэглэхийг зөвшөөрнө.

3. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ (үргэлжлэл)

3.5 2025 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн жилд заавал мөрдөхөөр заагаагүй стандартууд ба тайлбарууд шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн, эдгээрийг хугацаанаас өмнө хэрэгжүүлж эхлээгүй байна.

СТОУС/НББОУС	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийн гол агуулга	Хэрэгжих огноо
Санхүүгийн хэрэглүүрийн ангилал болон хэмжилтийн шаардлагатай холбоотой нэмэлт өөрчлөлт СТОУС 9 болон СТОУС 7	Санхүүгийн хэрэглүүрийн хэмжилт, ангилалтай холбоотой нэмэлт өөрчлөлт нь 2024 оны 5 сард гарсан бөгөөд СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүрийн хэмжилт болон ангиллын шаардлага, мөн СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүрийн тодруулгын шаардлагуудтай холбоотой хэрэгжилтийн дараах үнэлгээний хүрээнд хүлээн авсан саналд үндэслэн хийгдсэн. Дараах нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан. 1. Цахим төлбөрийн систем ашиглан барагдуулсан санхүүгийн өр төлбөрийг төлбөрийн огнооноос өмнө барагдуулсан гэж үзэх боломжтой нөхцөл 2. Болзошгүй үйл явдлын мөн чанар нь зээлийн эрсдэл болон зээлийн өртгийн өөрчлөлттэй шууд холбоогүй тийм нөхцөлийг агуулсан санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалын хэв шинжийг хэрхэн үнэлэх. 3. Бодит үнэ цэнийн зөрүү нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын тодруулгын шаардлагад нэмэлт өөрчлөлт оруулсан. Мөн зээлийн эрсдэл болон өртөгтэй шууд хамааралгүй нөхцөлт шинж чанарыг агуулсан санхүүгийн хэрэглүүрийн тодруулгын шаардлагыг нэмж тодорхойлсон.	2024 оны 5 сард батлагдсан бөгөөд 2026 оны 1 сарын 1-с хүчин төгөлдөр болно.
Байгалийн нөөцөд үндэслэсэн эрчим хүчний гэрээтэй холбоотой нэмэлт өөрчлөлт СТОУС 9 болон СТОУС 7	Байгалийн нөөцөд түшиглэсэн эрчим хүчний гэрээнүүдийн хувьд Гэрээний санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг илүү үнэн зөв илэрхийлэхийн тулд энэ төрлийн гэрээтэй холбоотой нэмэлт шаардлагуудыг СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр болон СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүрийн тодруулгад тусгаж өгсөн.	2024 оны 12 сард батлагдсан 2026 оны 1 сарын 1-с хүчин төгөлдөр болно
СТОУС-н Практик мэдэгдэл 1 Удирдлагын тайлбар	2010 оны 12 сард батлагдсан СТОУС-н практик мэдэгдэл 1 Удирдлагын тайлбарыг 2025 оны 6 сарын 23-нд бүрэн шинэчилж баталсан.	2025 оны 6 сард батлагдсан 2025 оны 6 сарын 23-с хүчин төгөлдөр болсон
Санхүүгийн тайлан дахь тодорхой бус байдлын тодруулга	Хэд хэдэн СТОУС-н хэрэгжүүлэх удирдамжид Санхүүгийн тайлан дахь тодорхой бус байдлын тодруулгатай холбоотой жишээ тайлбарыг нэмсэн. Эдгээр жишээ тайлбарын зорилго нь аж ахуйн нэгж хэрхэн стандартыг хэрэгжүүлж Санхүүгийн тайлан дахь тодорхой бус байдлын нөлөөг тайлагнахыг тайлбарлах, үлгэрлэн харуулах зорилготой. Эдгээр жишээ тайлбар нь СТОУС-н үндсэн зохицуулалт биш учраас хүчин төгөлдөр болох хугацаа, шилжилтийн шаардлага байхгүй.	Хамааралгүй

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШҮҮН ТУНГААЛТ

Компани нь эдгээр санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрсөн дүнгүүд болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн дансны дүнд нөлөөлөх тодорхой тооцоолол ба шүүн тунгаалт ашигладаг. Компанийн удирдлага түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шүүн тунгаалтыг тогтмол үнэлдэг бөгөөд бодит үр дүн нь тооцоолол ба шүүн тунгаалтаас ялгаатай байж болно.

Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд хамгийн их нөлөө үзүүлэх шийдлүүд болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнгүүдэд мэдэгдэхүйц тохируулга хийх шаардлага үүсгэж болох тооцооллуудад дараах зүйлс хамаарна. Үүнд:

4.1 Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт

Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг тодорхойлохын тулд тайлант үеийн эцэст санхүүгийн хэрэглүүрийн түүхэн дефолт болох эрсдэл болон анх хүлээн зөвшөөрөх үеийн дефолт болох эрсдэлийг харьцуулна. Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг үнэлэхдээ хугацаа хэтрэлтийн үзүүлэлтийг гол шалгуур болгон ашигладаг бөгөөд зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтийг хэмжиж үнэлэх арга нь тохиромжтой эсэхийг тогтмол хугацаатай хянадаг. Компани санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо зээлдэгчдийн ижил төстэй алдагдлын хандлагаар бүлэглэсэн дотоод зэрэглэлд суурилан тодорхойлсон хасагдуулгын хувь хэмжээг ашигладаг.

Компани ашиглаж болохуйц бүхий л боломжит бэлэн байгаа ирээдүйд чиглэсэн мэдээллийг хэт их зардал, хүчин чармайлт гаргалгүйгээр авч үздэг.

4.2 Санхүүгийн хөрөнгийн ангилал – бизнес загварын үнэлгээ

Хөрөнгийг эзэмшиж буй бизнесийн загвар болон мөнгөн урсгалын хэв шинжид үндэслэн санхүүгийн хөрөнгийг ангилна. Компанийн удирдлага санхүүгийн хөрөнгийн бизнесийн загварын үнэлгээг хийхдээ санхүүгийн хэрэглүүрүүдийн багц болон ижил байдлын түвшнийг тодорхойлохтой холбоотой үнэлэлт хийдэг. Санхүүгийн хөрөнгийн ижил төстэй байдлыг үнэлэхдээ борлуулалтын гүйлгээний түүхэн давтамж, цаг хугацаа болон үнэ цэн, борлуулалтын зорилго, ирээдүйн борлуулалтын үйл ажиллагааны хүлээлт зэргийг авч үздэг.

4.3 Бодит үнэ цэнийн хэмжилт

Зах зээлийн оролцогчдын хоорондох хэвийн ажил гүйлгээгээр хэмжилтийн өдөр хөрөнгийг борлуулснаар хүлээн авах, эсвэл өр төлбөрийг барагдуулснаар төлөх дүнгээр бодит үнэ цэнийг тодорхойлдог. Компани ажиглаж болохуйц холбогдох орцуудын ашиглалтыг хамгийн их, харин ажиглах боломжгүй орцуудын ашиглалтыг хамгийн бага байлгаснаар тухайн нөхцөл байдалд тохиромжтой бөгөөд бодит үнэ цэнийг хэмжих хангалттай тоон мэдээ бэлэн олдоцтой байх тийм үнэлгээний арга зүйг ашиглан бодит үнэ цэнийн үнэлгээг хийдэг бөгөөд хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо бодит үнэ цэнийн шатлал тус бүрээр хэмжиж үнэлдэг. Үүнд:

Түвшин 1 – ижил төрлийн хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн жишиг үнэ

Түвшин 2 – хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ашиглан шууд болон шууд бусаар ажиглах боломжтой бөгөөд 1-р түвшинд хамаарсан жишиг үнээс бусад орцуудад залруулга хийх замаар тооцоолсон дүн

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШҮҮН ТУНГААЛТ **(үргэлжлэл)**

4.3 Бодит үнэ цэнийн хэмжилт (үргэлжлэл)

Түвшин 3 – хэмжилтийн өдөр тухайн хөрөнгө, өр төлбөртэй холбоотой зах зээлийн үйл ажиллагаа байхгүй буюу маш бага байх тохиолдолд бодит үнэ цэнийн хэмжилтэд ажиглах боломжгүй орцуудыг ашиглан тооцоолсон дүн.

2 болон 3-р түвшний үнэлгээг компанийн удирдлага нь хөндлөнгийн үнэлгээчний тусламжтайгаар тодорхой хугацааны давтамжтайгаар хянадаг. Удирдлагын зүгээс үнэлгээний загварын өгөгдөл болон санхүүгийн тайлангийн зориулалттай хөрөнгийн үнэлгээнд хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний арга аргачлалыг ашиглаж хийсэн эсэхийг хянах замаар үнэлгээний дүгнэлтийн зохистой байдлыг авч үздэг.

4.4 Элэгдүүлэх хөрөнгийн ашиглалтын хугацаа

Компанийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтад суурилан тайлант үе бүрийн эцэст биет бус хөрөнгө, үндсэн хөрөнгө зэрэг элэгдүүлдэг хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр дүн нь магадгүй техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болох юм. Тайлант хугацааны эцэст хөрөнгийн ашиглалтын хугацаанд өөрчлөлт оруулаагүй.

Удирдлага үндсэн хөрөнгийн одоогийн ашиглалтын жил уг хөрөнгийн бодитой эдийн засгийн ашиглалтын жил гэдэгт итгэлтэй байдаг.

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

5.1. Санхүүгийн хөрөнгө

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд гар дээрх мөнгө, санхүүгийн байгууллагад хадгалагдаж байгаа мөнгө, бусад богино хугацаатай, 3 сар эсвэл түүнээс богино хугацаанд мөнгө болох чадвартай, үнийн өөрчлөлтөд өртөмтгий бус хөрөнгө оруулалт болон банкны овердрафт багтана. Банкны овердрафтыг балансын эргэлтийн хөрөнгийн хэсэгт харуулна.

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Санхүүгийн хөрөнгийг анхны удаа түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэн нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнд ажил гүйлгээний зардлыг нэмж оруулна. Бодит үнэ цэн нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд ажил гүйлгээний зардлыг тайлант үеийн ашиг алдагдалд тайлагнана.

Ангилал

Санхүүгийн хөрөнгийг уг хөрөнгүүдийг удирдан зохицуулах тухайн аж ахуйн нэгжийн бизнесийн загвар болон гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанараас нь хамааруулан дараах байдлаар ангилна.

(i) Дараагийн тайлант үе бүрд хорогдуулсан өртгөөр хэмжих

Санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөл нь тогтоосон өдрүүдээр гэрээний мөнгөн гүйлгээ үүсгэхэд хүргэдэг бөгөөд гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулан авахын тулд эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүр.

(ii) Бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бүртгэгдэх

Санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөл нь тогтоосон өдрүүдээр мөнгөн гүйлгээ үүсгэхэд хүргэдэг бөгөөд гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулан авах болон санхүүгийн хөрөнгийн борлуулах гэсэн аль аль зорилтойгоор эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүр.

Мөн бодит үнэ цэнийн дараагийн тайлант үеүдийн өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогод толилуулах эргэлт буцалтгүй сонголтыг хийсэн өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт энэ ангилалд хамаарна.

(iii) Тайлант үеийн ашиг алдагдалд бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бүртгэгдэх,

Хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэнээр бусад санхүүгийн хэрэглүүр.

Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт

Дараагийн тайлант үе бүрд хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгийг үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгийг дараа үеүдэд бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө.

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.1. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт (үргэлжлэл)

- ✓ Бодит үнэ цэн нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд ашиг, алдагдлын тайланд бусад орлого эсвэл бусад зардлаар
- ✓ Бодит үнэ цэн нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгийн хувьд дансны үнийн бусад өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор

Бодит үнэ цэн нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс олсон хүүгийн орлогыг цэвэр олз, гарзаар тайлагнана. Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хөрөнгө оруулалт болон зээл ба авлагын хүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Үл хүлээн зөвшөөрөлт

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

- ✓ Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг хүлээж авах эрхийн хугацаа дууссан; эсвэл
- ✓ Компани нь санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг авах эрхийг шилжүүлсэн бөгөөд (а) санхүүгийн хөрөнгийн эрсдэл, өгөөж бүрэн шилжсэн; эсвэл (б) бүх эрсдэл, өгөөж болон хөрөнгийг шилжүүлээгүй боловч захирах эрхийг нь шилжүүлсэн байх

Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх тохиолдолд бусад дэлгэрэнгүй орлогод өмнө нь хүлээн зөвшөөрч байсан хуримтлагдсан олз, гарзыг дахин ангилах залруулга байдлаар өмчөөс ашиг, алдагдалд дахин ангилна.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Аж ахуйн нэгж хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө болон бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтыг хэмжиж бүртгэнэ.

Аж ахуйн нэгж нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй алдагдлыг дараах зүйлсийг тусгах байдлаар хэмжиж, гарзын хасагдуулаг байдлаар хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- a. Боломжит үр дүнгүүдийн хамаарах мужийг үнэлэх замаар тодорхойлдог, хэт нэг талыг баримтлаагүй магадлалаар жинлэсэн дүн
- b. Мөнгөний цаг хугацааны үнэ цэн
- c. Их зардал буюу хүчин чармайлт гаргахгүйгээр тухайн тайлант үеийн эцсээр олж авч болох бөгөөд өнгөрсөн үйл явдал одоогийн нөхцөл байдал, ирээдүйн эдийн засгийн төлөв байдлын прогнозын талаарх ул үндэслэлтэй ба дэмжих мэдээлэл.

Компани үнэ цэнийн бууралтын алдагдлын санг 12 сарын хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сангаар хэмжих ба дараахаас бусад хөрөнгийн хувьд уг хөрөнгийн ашиглалтын хугацааны турших хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сангаар хэмждэг. Үүнд:

Тайлангийн өдрөөр хүлээгдэж буй эрсдэлийг бага гэж тодорхойлсон өрийн үнэт цаас; болон анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн хөрөнгийн эрсдэлд мэдэгдэхүйц нөлөө үүсээгүй бусад санхүүгийн хэрэгслүүд (санхүүгийн түрээсэнд оруулсан цэвэр хөрөнгө хөрөнгө оруулалтаас бусад).

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.1. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт

Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь зээлийн алдагдлын магадлалаар жинлэсэн тооцоолол юм. Энэ нь дараах байдлаар хэмжигдэнэ. Үүнд:

- Төлбөр төлөгдөхгүй байх магадлал: Төлбөр төлөгдөхгүй байх магадлал гэдэг нь тодорхой хугацааны туршид чанар муудах боломжит нөхцөлийн үнэлгээ. Төлбөр төлөгдөхгүй байх магадлал нь тухайн санхүүгийн хэрэгсэл өмнө нь данснаас хасагдаагүй, зээлийн багцад хэвээр байгаа тохиолдолд үнэлэгдэж буй хугацааны тодорхой мөчид үүсэж болно.
- Чанаргүйдэлд өртөх дүн: Чанаргүйдэлд өртөх дүн гэдэг нь тайлагналын өдрөөс хойш үндсэн болон хүүгийн төлбөр гэрээнд заасан төлөлт болон бусад, урьдчилан зөвшөөрсөн зээлийн шугамын ашиглалт, мөн хугацаа хоцорсон төлөлтөөс үүсэх хуримтлагдсан хүү зэрэг өртгийн өөрчлөлтүүдийг харгалзан чанар муудалт гарах ирээдүйн өдрөөр тооцоолсон өртгийн хэмжээ.
- Алдагдал үүсэх магадлал: Алдагдал үүсэх магадлал гэдэг нь төлбөр төлөгдөхгүй байх магадлал тодорхой хугацаанд гарсан тохиолдолд Компанид үүсэх алдагдлын төсөөлөл. Энэ нь гэрээний дагуу хүлээгдэж буй мөнгөн урсгал болон Компанийн бодитоор хүлээн авахаар тооцож буй мөнгөн урсгалын зөрүүнд үндэслэнэ.

5.2. Санхүүгийн өр төлбөр

Компани өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилдаг.

- ✓ Бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр
- ✓ Бусад санхүүгийн өр төлбөр

Бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр

Бодит үнэ цэн нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай санхүүгийн үүсмэл хэрэглүүр багтана. Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг Санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Орлого үр дүнгийн тайланд тусгана. Ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.2. Санхүүгийн өр төлбөр (үргэлжлэл)

Бусад санхүүгийн өр төлбөр

Бусад санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс багтана.

- Банкны зээл болон бусад хүү тооцогдох санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Санхүүгийн өр төлбөрийн хүүгийн зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү, эсвэл купон багтана.
- Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн дансны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүгийн түвшнийг хэрэглэн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Компани санхүүгийн өр төлбөрийг тус өр төлбөртэй холбоотой үүрэг хариуцлага цуцлагдсан, чөлөөлөгдсөн болон хугацаа нь дуусгавар болсон үед үл хүлээн зөвшөөрнө.

5.3. Бараа материал

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Бараа материал нь бизнесийн хэвийн үйл ажиллагаа эсвэл үйлдвэрлэлийн процесс юм уу үйлчилгээ үзүүлэхэд ашиглах зорилгоор олж эзэмшсэн түүхий эд материал, хангамжийн зүйлс, сэлбэг хэрэгслээс бүрдэнэ.

Бараа материалыг олж эзэмшихэд өртөг бүрдэх зарчмыг үндэслэн тодорхойлсон анхны өртгөөр бүртгэх ба өртөг нь худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил, нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан зардлаас бүрдэнэ.

Өртөг тооцох

Бараа материалыг зарлагадахдаа “Жинлэсэн дундаж өртгийн арга”-ыг ашиглана. Дундаж өртгийг тодорхойлохдоо ижил төрлийн барааны хувьд тайлант хугацааны эхний үлдэгдэл, тайлант үеийн туршид худалдан авсан бараа материалын дундажаар тооцно.

Санхүүгийн тайлангаарх бараа материалын үлдэгдлийг өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнана. Цэвэр боломжит үнэ цэн нь бизнесийн хэвийн ажиллагааны үеийн бараа материалын борлуулах үнээс түүнийг борлуулахтай холбогдон гарах зардлыг хассан дүн байна.

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.4. Үндсэн хөрөнгө

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Бүх үндсэн хөрөнгө түүхэн өртгөөс элэгдлийг хассан дүнгээр тусгагдана. Түүхэн өртөгт хөрөнгийг худалдан авахтай шууд холбоотой зардлууд багтана. Мөн өртөгт гадаад валютаар худалдан авсан үндсэн хөрөнгийн мөнгөн урсгалын хэйджийн олз/гарзын өмчийн дүнгээс шилжүүлсэн хэсэг орно. Дараагийн үеийн зардлуудыг хөрөнгийн дансны үнэд багтаах эсвэл тухайн хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг хүртэх боломжтой, өртгийг нь найдвартай тооцох боломжтой бол тусдаа хөрөнгөөр бүртгэнэ. Тусдаа хөрөнгөөр бүртгэгдсэн хэсгийг орлуулсан үед дансны үнээр нь үл хүлээн зөвшөөрнө. Бусад засвар үйлчилгээтэй холбоотой гарсан зардлыг гарсан үед нь тайлант хугацааны ашиг алдагдлын тайланд тусгана.

Данснаас хассанаас үүссэн олз, гарзыг хөрөнгийн дансны үнийг хүлээн авсан төлбөртэй нь харьцуулан тодорхойлох ба тэдгээрийг ашиг алдагдлын тайланд тусгана.

Дараа үеийн зардал

Сольж тавьсан эд анги, хэсэг нь ирээдүйд эдийн засгийн үр өгөөж компанид өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед барилга, тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг тайланд хөрөнгийн дансны үнэнд нэмж хүлээн зөвшөөрнө. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна. Барилга, тоног төхөөрөмжийн өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулдаг ба дараах байдалтай байна.

Үндсэн хөрөнгийн бүлэг	Элэгдэл байгуулах жил
Тавилга эд хогшил	10
Компьютер дагалдах хэрэгсэл	2
Бусад хөрөнгө	10

5.5. Биет бус хөрөнгө

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд аж ахуйн нэгж хяналтдаа авсан бөгөөд ирээдүйд эдийн засгийн өгөөж өгөхөөр хүлээгдэж байгаа тодорхойлж болохуйц, биет шинж чанаргүй хөрөнгийг биет бус хөрөнгөөр ангилна. Биет бус хөрөнгийн тодорхойлолтыг хангаж буй хөрөнгүүдийн хувьд тухайн хөрөнгөөс хүлээгдэж буй эдийн засгийн өгөөж нь аж ахуйн нэгжид орох магадлалтай бөгөөд хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой үед өртгөөр нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Компани биет бус хөрөнгийн дараа үеийн хэмжилтэд өртгийн загвар ашигладаг бөгөөд тайлангийн хугацааны эцэст хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан хорогдол, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр санхүүгийн тайланд толилуулдаг.

Хорогдол

Биет бус хөрөнгийн хорогдлыг 10 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар байгуулдаг.

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.6. Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнийг нягтлан үзэж үнэ цэн буурсан байх шинж байгаа эсэхийг тодорхойлно. Хэрэв үнэ цэн буурсан шинж илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцно. Үнэ цэнийн бууралтыг шалгахдаа хөрөнгүүдийг бүлэглэх ба ингэхдээ бусад хөрөнгүүд болон мөнгө үүсгэгч нэгжүүдээс орох мөнгөн урсгалаас ангид, дангаараа цаашид үргэлжлүүлэн ашигласнаар мөнгөн орох урсгал бий болгох хөрөнгүүдийн хамгийн жижиг бүлэг байхаар бүлэглэнэ. Тухайн хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн нөхөгдөх дүнг ашиглалтын үнэ цэн болон бодит үнэ цэнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан цэвэр дүнгийн аль ихээр тооцно. Ашиглалтын үнэ цэн нь татварын өмнөх дискаунтын түвшин (мөнгөний үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээ болон тухайн хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн эрсдэл зэргийг агуулсан)-г ашиглан ирээдүйн тооцсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр тооцогдоно.

Хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс их бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө.

5.7. Нөөц

Компани нь өнгөрсөн үйл явдлын улмаас хуулиар үүрэг хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд энэхүү үүргийг барагдуулахад эдийн засгийн өгөөжийг зарцуулах өндөр магадлалтай бөгөөд үүрэг хариуцлагыг бодитоор хэмжих боломжтой бол нөөцийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Бүртгэлд тусгагдсан нөөцийн дүн нь үүссэн өрийг төлж барагдуулахад шаардагдах мөнгөн дүнгийн хэмжээг тайлант жилийн эцсийн байдлаар тухайн өртэй холбоотой нөхцөл байдал, эрсдэлийг харгалзан тооцоолсон удирдлагын хийж чадах хамгийн сайн тооцоололд үндэслэдэг. Одоогийн үүссэн өрийг барагдуулахад хэрэгтэй тооцоолж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн нөөцийг хэмждэг ба түүний дансны дүн нь тэдгээр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тодорхойлогддог. Нөөцийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин хянах ба тайлант хугацааны эцэст хамгийн сайн тооцооллыг тусгаж залруулдаг. Эдийн засгийн өгөөжийг шилжүүлж өр төлбөрийг барагдуулах шаардлагагүй болсон үед нөөцийг буцаана.

5.8. Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө

Аж ахуйн нэгжийн бүрэн хяналтаас гадуурх нэг болон түүнээс дээш ирээдүйн үйл явдал тохиолдох, эс тохиолдохоос хамаарч үүсэх эсэх нь тодорхойлогддог тул болзошгүй өр ба болзошгүй хөрөнгийг бүртгэдэггүй. Эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөцийн гадагш урсгал гарах магадлал маш бага биш л бол бүх тохиолдолд болзошгүй өр төлбөрийг санхүүгийн тайланд нэмж тодруулна.

5.9. Өөрийн хөрөнгө

Хувьцаат капитал

Энгийн хувьцаа болон давуу эрхийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилдаг. Энгийн хувьцаа, давуу эрхийн хувьцаа болон хувьцааны опционыг гаргахтай шууд холбогдон гарах нэмэлт зардлыг аливаа татварын нөлөөлөлгүй цэвэр дүнгээр өмчийн хэсгийг бууруулах байдлаар хүлээн зөвшөөрнө. Худалдан авах, эргүүлэн худалдан авах, худалдан авах опцион зэргийг агуулаагүй энгийн хувьцаа болон давуу эрх эрхийн хувьцааг өмчийн хэсэгт ангилдаг.

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.9. Өөрийн хөрөнгө (үргэлжлэл)

Нэмж төлөгдсөн капитал

Хувьцааны нэрлэсэн үнээс хэтэрсэн дүнг нэмж төлөгдсөн капитал гэж үзнэ. Нэмж төлөгдсөн капитал нь мөн хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийн нэмэгдлээс үүсдэг.

Хуримтлагдсан ашиг

Компани үүсгэн байгуулснаас хойших хугацаанд компанид хуримтлагдсан ашиг, алдагдлын нийлбэрийг хуримтлагдсан ашиг дансанд бүртгэх ба оруулсан хөрөнгийг ашиглан бий болгосон нэмэлт эх үүсвэрийн хэмжээг харуулна.

5.10. Хүүгийн орлого, зардал

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн үр ашигт хүүгийн түвшнийг тэдгээрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед тооцоолно. Хүүгийн орлого ба зардлыг тооцоолохдоо, хөрөнгийн дансны нийт дүнд (хөрөнгө нь үнэ цэнийн бууралтгүй байх үед) эсвэл өр төлбөрийн хорогдуулсан өртөгт үндэслэн үр ашигт хүүгийн хувиар тооцоолно.

Гэсэн хэдий ч, анхны хүлээн зөвшөөрөлтийн дараагаар үнэ цэнийн бууралттай болсон санхүүгийн хөрөнгүүдийн хувьд, санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөгт үндэслэн үр ашигт хүүгийн хувиар хүүгийн орлогыг тооцоолно. Хэрэв тухайн хөрөнгө нь цаашид үнэ цэнийн бууралтгүй болбол хүүгийн орлогын тооцоолол нь буцаад дансны нийт дүнгийн сууриар тооцоологдоно.

Санхүүгийн хөрөнгийн хувьд анхны хүлээн зөвшөөрөлтөөр үнэ цэнийн бууралттай байсан бол санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөгт үндэслэн зээлийн эрсдэлээр тохируулсан үр ашигт хүүгийн хувиар хүүгийн орлогыг тооцоолно.

Толилуулга

Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдсан үр ашигт хүүгийн орлогод дараах зүйлсийг бүртгэнэ:

- хорогдуулсан өртгөөр санхүүгийн хөрөнгийн хүү;
- БҮЦБДО-р хэмжигдсэн өрийн хэрэгслүүдийн хүү;

Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдсан хүүгийн зардалд дараах зүйлсийг бүртгэнэ:

- хорогдуулсан өртгөөр санхүүгийн өр төлбөр;
- түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал.

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.11. Хураамж ба шимтгэл

Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрт нөлөөлөх үр ашигт хүүгийн хэмжилтэд хураамж ба шимтгэлийн орлого, зардал багтдаг.

Бусад хураамж ба шимтгэлийн орлогод дансны үйлчилгээний хураамж, хөрөнгө оруулалтын удирдлагын хураамж, борлуулалтын хураамж, байршуулалт болон хөрвүүлэлтийн хураамж зэрэг орох бөгөөд холбогдох үйлчилгээг үзүүлэх үед нь хүлээн зөвшөөрдөг.

5.12. Түрээс (Компани – түрээслэгч)

Компани нь гэрээний эхэнд гэрээ нь түрээс, эсвэл түрээс агуулсан эсэхийг үнэлдэг. Хэрэв гэрээ нь төлбөрийн хариуд тухайн тодорхойлсон хөрөнгийн ашиглалтыг хянах эрхийг шилжүүлдэг бол уг гэрээ нь түрээс болно, эсвэл түрээсийг агуулсан байна.

Ашиглах эрхтэй хөрөнгө

Компани нь ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн өдрөөс эхлэн өртгөөр нь хүлээн зөвшөөрдөг. Ашиглах эрхтэй хөрөнгийн өртөгт түрээсийн өр төлбөр, хүлээн авсан түрээсийн эхний өртөг, түрээсийн урамшууллыг авалгүйгээр эхлэхээс өмнө хийсэн түрээсийн төлбөрүүд орно. Ашиглах эрхтэй хөрөнгийг дараа үеүдэд өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжинэ. Ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

Түрээсийн өр төлбөр

Түрээсийн эхлэх өдөр Компани нь түрээсийн нийт хугацааны туршид хийгдэх түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнээр түрээсийн өглөгийг хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөрт тогтмол төлбөр (түрээсийн урамшууллыг аваагүй), индекс эсвэл хувь хэмжээнээс хамааран хувьсах түрээсийн төлбөрүүд, үлдэгдэл үнийн баталгааны дагуу төлөх хүлээгдэж буй төлбөрүүд орно. Индекс эсвэл хувь хэмжээнээс хамааралгүй хувьсах түрээсийн төлбөрийн тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрнө.

Түрээсийн хүүгийн хэмжээг тодорхойлох боломжгүй тохиолдолд Компани нь түрээс эхлэх үеийн зээлийн өсөн нэмэгдэх хүүг ашиглан түрээсийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолно. Түрээс эхэлсэн өдрөөс хойш түрээсийн өр төлбөрийг хуримтлагдсан хүүгээр нэмэгдүүлж, төлсөн түрээсийн төлбөрөөр бууруулдаг. Мөн түүнчлэн түрээсийн хугацаанд өөрчлөлт оруулах, тогтмол төлбөрийн шинж чанарт өөрчлөлт оруулах эсвэл уг хөрөнгийг худалдаж авах үнэлгээнд өөрчлөлт оруулах зэрэг өөрчлөлтүүд гарсан тохиолдолд түрээсийн өр төлбөрийн дүнг дахин тооцоолно.

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.13. Гадаад валютаарх ажил гүйлгээ ба үлдэгдэл

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг уг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба түүхэн өртгөөр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлдэг. Гадаад валютын ханшийн зөрүүг ашиг эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Тайлант хугацаанд хэрэглэсэн ханш доорх байдалтай байна. Үүнд:

Валют нэр		Хаалтын ханш /төгрөг/	
		2025.12.31	2024.12.31
AUD	Австрали доллар	2,385.63	2,133.21
CAD	Канад доллар	2,599.23	2,375.50
CHF	Швейцар франк	4,509.81	3,792.90
CNY	БНХАУ юань	508.78	468.57
EUR	Евро	4,186.72	3,566.98
GBP	Англи фунт	4,804.69	4,303.87
HKD	Хонконг доллар	457.17	440.61
JPY	Япон иен	22.81	21.67
KRW	БНСУ вон	2.46	2.32
RUB	ОХУ рубль	45.22	32.85
SEK	Швед крон	387.75	311.03
SGD	Сингапур доллар	2,770.20	2,522.31
THB	Тайланд бат	112.87	100.76
TRY	Турк лира	82.82	96.97
USD	Америк доллар	3,556.66	3,420.25

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.14. Татварын бүртгэл

Орлогын албан татвар

Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр хэрэгжиж байсан эсвэл ирээдүйд хэрэгжих хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн жилийн татварын зардал болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн жил эсвэл өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл өмчид шууд бүртгэснээс бусад тохиолдолд тухайн жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрөгдөнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр толбор

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм. Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг татвар ногдуулах нэг аж ахуйн нэгжид хамаарах татварын байгууллагаас тогтоосон тайлант үеийн татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөрийн эсрэг хуулийн эрх үүргийн дагуу хооронд нь хааж болох бөгөөд гэхдээ эдгээр татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөр нь цэвэр дүнд суурилсан байх хэрэгтэй. Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрд хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

5.15. Ажилчдын тэтгэмж

Ажилтан аж ахуйн нэгжид үзүүлсэн үйлчилгээний хариуд тайлант үеийн эцсээс хойших арван хоёр сарын хугацаанд багтаан авахаар тохиролцсон ажилтны тэтгэмж болох цалин, хөлс болон мөнгөн бус тэтгэмжүүдийг тайлант хугацааны эцсийг хүртэлх хугацаанд үзүүлсэн үйлчилгээнд суурилан хүлээн зөвшөөрөх ба төлбөрийг барагдуулах үед төлөгдөх дүнгээр хэмжинэ.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд хуулийн дагуу улсын тэтгэврийн болоод нийгэм, эрүүл мэндийн даатгалын сангуудад шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлүүдийг үүссэн үед нь ашиг, алдагдалд зардлаар бүртгэдэг.

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.16. Холбоотой талууд

Холбоотой тал гэдэг нь санхүүгийн тайлан бэлтгэж байгаа байгууллагатай холбоотой хүн эсвэл байгууллага юм. Тухайн хүн эсвэл тэр хүний гэр бүлийн ойрын гишүүн нь тайлагнагч байгууллагатай холбоотой бөгөөд уг хүн нь:

1. Тайлагнагч байгууллагад хяналттай эсвэл хамтарсан хяналттай,
2. Тайлагнагч байгууллагад үлэмж хэмжээний нөлөөтэй,
3. Тайлагнагч байгууллага, тайлагнагч байгууллагын толгой компанийн гол удирдлагын багийн гишүүн байх,

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг оршин байгаа бол байгууллага нь тайлагнагч байгууллагатай холбоотой гэж үзнэ. Үүнд:

1. Байгууллага ба тайлагнагч байгууллага нь нэг ижил байгууллагын (энэ нь толгой, охин болон дэд охин компани нь бусадтай холбоотой байх) гишүүд байх,
2. Нэг байгууллага нөгөө байгууллагын хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх (эсвэл нөгөө байгууллагын гишүүнчлэлтэй нэг гишүүний хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх),
3. Хоёр компани нь нэг ижил гуравдагч талын хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын талууд байх,
4. Нэг байгууллага нь гуравдагч байгууллагын хамтарсан үйлдвэр/хамтарсан хөрөнгө оруулалтын нэг хэсэг болох ба нөгөө байгууллага нь гуравдагч байгууллагын хараат компани болох,
5. Байгууллага нь тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагатай холбоотой байгууллагын аль алины ажилчдын тэтгэмжийн “ажил эрхлэлтийн дараах тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө”-нд хамаарах. Хэрэв тайлагнагч байгууллага нь өөрөө энэ төлөвлөгөөний нэг хэсэг бол спонсор ажил олгогчид нь тайлагнагч байгууллагатай мөн холбоотой талууд болно.
6. Байгууллагад (а)-д тодорхойлогдсон хүн хяналт тавьдаг эсвэл хамтарсан хяналт тавьдаг байх,
7. (а), (а)-д тодорхойлогдсон хүн нь байгууллагад үлэмж нөлөө үзүүлдэг эсвэл байгууллагын (эсвэл байгууллагын толгой компанийн) гол удирдлагын багийн гишүүн байх,
8. Байгууллага, эсвэл нэг хэсэг нь болж байгаа өөр бусад гишүүн, тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагын толгой компани руу гол удирдлагын ажилтнаар хангах.

6. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

6.1. ТОДРУУЛГА-МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Бэлэн мөнгө	850,476,755	
Банкин дахь харилцах данс	12,794,573,637	6,109,520,030
Банкин дахь хугацаат хадгаламж	10,500,000	10,506,091,015
Дүн	13,655,550,392	16,615,611,045

Тайлант хугацааны эцэст гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тайлангийн хугацааны эцэс дэх Монгол банкнаас зарласан хаалтын ханшаар тэгшитгэн толилуулсан. Мөнгөн хөрөнгийн гүйлгээ, үлдэгдэлд аливаа хязгаарлалт тавигдаагүй.

6.2. ТОДРУУЛГА-ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Иргэнд олгосон зээл	73,749,714,754	59,813,881,495
Хэрэглээний зээл	48,161,864,149	38,950,511,239
Бизнесийн зээл	17,711,716,148	14,879,454,268
Автомашинны зээл	7,876,134,457	5,933,122,723
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл		50,793,265
Хуулийн этгээдэд олгосон зээл	30,839,350,369	18,638,651,740
Бизнесийн зээл	30,778,682,127	18,638,651,740
Автомашинны зээл	60,668,242	
Нийт зээл	104,589,065,123	78,452,533,235
Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	9,403,701,749	5,104,454,405
Хасах: Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа төлбөрийн хүлээгдэж буй алдагдлын нөөц	(5,053,343,056)	(2,758,037,800)
Харилцагчдад олгосон цэвэр зээл ба урьдчилгаа	108,939,423,816	80,798,949,840
Үүнээс:		
Урт хугацаанд төлөгдөх	63,838,004,592	44,348,632,197

“СЭНДЛИ ББСБ” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жил

Нийт зээлийн багцын зээлжих чанарыг дараах байдлаар харуулав:

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Хэвийн зээл	95,036,105,041	73,124,802,239
Анхаарал хандуулах зээл	2,350,474,305	1,199,151,921
Хэвийн бус зээл	1,541,073,709	784,253,314
Эргэлзээтэй зээл	2,221,722,308	1,684,617,771
Муу зээл	3,439,689,760	1,659,707,990
Дүн	104,589,065,123	78,452,533,235

Хасах: Үнэ цэнийн бууралтын хасагдуулаг

Хэвийн	=	=
Анхаарал хандуулах	(117,523,716)	(59,957,596)
Хэвийн бус	(385,268,427)	(196,063,329)
Эргэлзээтэй	(1,110,861,153)	(842,308,885)
Муу	(3,439,689,760)	(1,659,707,990)
Дүн	(5,053,343,056)	(2,758,037,800)

Цэвэр дүн	99,535,722,067	75,694,495,435
------------------	-----------------------	-----------------------

Зээлийн авлагын үнэ цэнийн бууралтын хасагдуулгын хөдөлгөөн

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Эхний үлдэгдэл	2,758,037,800	1,636,005,721
Тайлант жилд байгуулсан /цэвэр/ Данснаас хассан	2,295,305,256	1,122,032,079
Эцсийн үлдэгдэл	5,053,343,056	2,758,037,800

Компани нь 1,500,000 мянган төгрөгийн хэвийн зээлийн багцаа банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн барьцаанд байршуулсан байна.

6.3. ТОДРУУЛГА-ФАКТОРИНГ ТООЦООНЫ АВЛАГА

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Факторинг тооцооны авлага	28,256,156	28,256,156
Дүн	28,256,156	28,256,156

6.4. ТОДРУУЛГА-БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Байгууллагаас авах авлага	363,169,233	850,425,929
Бусад авлага	813,429,248	334,667,413
Дүн	1,176,598,481	1,185,093,342
Хасах: Бусад авлагын хүлээгдэж буй алдагдлын нөөц	(361,321,923)	-
Цэвэр дүн	815,276,558	1,185,093,342

Нийт бусад авлагын зээлжих чанарыг дараах байдлаар харуулав:

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Хэвийн	690,576,302	1,185,093,342
Анхаарал хандуулах	89,191,237	-
Хэвийн бус	30,221,827	-
Эргэлзээтэй	34,604,422	-
Муу	332,004,693	-
Дүн	1,176,598,481	1,185,093,342
<i>Хасах: Үнэ цэнийн бууралтын хасагдуулаг</i>		
Хэвийн		
Анхаарал хандуулах	(4,459,562)	-
Хэвийн бус	(7,555,457)	-
Эргэлзээтэй	(17,302,211)	-
Муу	(332,004,693)	-
Дүн	(361,321,923)	-
Цэвэр дүн	815,276,558	1,185,093,342

Бусад авлагын үнэ цэнийн бууралтын хасагдуулгын хөдөлгөөн:

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Эхний үлдэгдэл	-	-
Тайлант жилд байгуулсан /цэвэр/	361,321,923	-
Данснаас хассан	-	-
Эцсийн үлдэгдэл	361,321,923	-

“СЭНДЛИ ББСБ” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жил

6.5. ТОДРУУЛГА-ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Иргэдээс татсан итгэлцлийн өглөг	27,354,752,126	18,144,218,450
Байгууллагаас татсан итгэлцлийн өглөг	1,773,700,000	7,613,891,240
Итгэлцлийн хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,972,817,821	1,572,923,709
Дүн	31,101,269,947	27,331,033,399
Хасах: Хойшлогдсон төлбөр	(55,520,810)	=
Цэвэр дүн	31,045,749,137	27,331,033,399
Үүнээс		
Урт хугацаанд төлөгдөх	4,095,486,961	2,128,302,449

Эдгээр итгэлцлийн санхүүжилтийн жилийн хүүгийн түвшин 11%-25% (2024 онд: 10%-20.4%) хүртэл хэлбэлзэж байгаа бөгөөд төлбөрийн хугацаа нь 2026 оны 01 дүгээр сарын 03-наас 2027 оны 12 дугаар сарын 19-ний хооронд байна.

6.6. ТОДРУУЛГА-БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ТАТСАН ЭХ ҮҮСВЭР

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	1,016,500,000	18,311,500,000
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	23,135,880,000	2,791,266,025
Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	183,449,236	119,943,008
Дүн	24,335,829,236	21,222,709,033
Хасах: Хойшлогдсон шимтгэлийн зардал	(1,057,757,182)	=
Цэвэр дүн	23,278,072,054	21,222,709,033
Үүнээс:		
Урт хугацаанд төлөгдөх	22,135,880,000	2,777,535,737

Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл

Репо нөхцөлтэй зээл: 2025 оны турш нийт 18 удаагийн гэрээгээр 7,500,000 мянган төгрөгийг 7, 14, 28, 84 хоногийн хугацаатайгаар, 20.0%-22.5%-ийн хүүгийн түвшинтэйгээр зээлсэн. 2025 оны 12 сарын 31 өдрийн байдлаар 2 зээлийн гэрээний 1,000,000 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Монголын тогтвортой санхүүжилтийн хөгжлийн холбооноос олгосон санхүүжилт: Компани 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Монголын тогтвортой санхүүжилтийн хөгжлийн холбоотой Монгол улсад агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор ББСБ-ын олгосон ногоон зээлийн багцад санхүүжилт олгох ТОС 24/72 дугаартай "Хамтран ажиллах гэрээ" байгуулсан. Олгосон санхүүжилтийн хэмжээ 16,500 мянган төгрөг, жилийн 8 хувийн хүүтэй, 36 сарын хугацаатай.

“СЭНДЛИ ББСБ” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жил

Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл

Компани Сингапурын Alt Income Investment SDI PTE LTD компанитай дараах зээлийн гэрээнүүдийг байгуулсан байна. Үүнд:

- 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр жилийн 13 хувийн хүүтэй, 36 сарын хугацаатай 2,000,000 ам.долларын зээлийн гэрээ байгуулсан.
- 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдөр жилийн 13 хувийн хүүтэй, 36 сарын хугацаатай 1,000,000 сингапур долларын зээлийн гэрээ байгуулсан.
- 2025 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр жилийн 13 хувийн хүүтэй, 36 сарын хугацаатай 2,000,000 сингапур долларын зээлийн гэрээ байгуулсан.
- 2025 оны 07 дугаар сарын 14-ны өдөр жилийн 13 хувийн хүүтэй, 36 сарын хугацаатай 1,000,000 сингапур долларын зээлийн гэрээ байгуулсан.
- 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдөр жилийн 13 хувийн хүүтэй, 37 сарын хугацаатай 1,000,000 ам.долларын зээлийн гэрээ байгуулсан.

6.7. ТОДРУУЛГА-БУСАД ЭХ ҮҮСВЭР

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Гаргасан өрийн бичиг-ҮЦТХТ	15,000,000,000	15,000,000,000
Өрийн бичгийн хуримтлагдсан хүүгийн өглөг	275,901,371	275,901,370
Дүн	15,275,901,371	15,275,901,371
Хасах: Хойшлогдсон төлбөр	(201,528,175)	-
Цэвэр дүн	15,074,373,196	15,275,901,371
Үүнээс:		
<i>Урт хугацаанд төлөгдөх</i>		<i>15,000,000,000</i>

Компани 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдөр нэгж нь 100.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 100,000 ширхэг бондыг 18 сарын хугацаатай, жилийн 18.5 хувийн хүүгийн түвшинд, хүүг улирал тутамд төлөх нөхцөлтэйгөөр Монголын хөрөнгийн биржээр нээлттэй гаргасан.

Мөн 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр нэгж нь 100.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 50,000 ширхэг бондыг 18 сарын хугацаатай, жилийн 20.0 хувийн хүүгийн түвшинд, хүүг улирал тутамд төлөх нөхцөлтэйгөөр биржийн бус зах зээлээр хаалттай хүрээнд гаргасан.

6.8. ТОДРУУЛГА-ХОЁРДОГЧ ӨР ТӨЛБӨР

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Эхний үлдэгдэл	-	-
Нэмэгдсэн	11,576,260,260	-
Хүүгийн зардал	753,004,015	-
Хүүгийн төлбөр	(699,528,776)	-
Ханшийн зөрүү	(154,359,320)	-
Эцсийн үлдэгдэл	11,475,376,179	-
Хасах: Хойшлогдсон төлбөр	(495,337,932)	-
Цэвэр дүн	10,980,038,247	-
Үүнээс:		
Урт хугацаанд төлөгдөх	10,980,038,247	-

Компани тайлант хугацаанд дараах хөрвөх нөхцөлтэй эх үүсвэрүүдийг татан төвлөрүүлсэн байна.

- 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр №S-25/8 дугаартай “Хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татан төвлөрүүлэх гэрээ”-г байгуулан 2,000,000 ам.долларын хугацааны эцэст компанийн энгийн хувьцаанд хөрвөх боломжтой өрийн хэрэгслийг 13 хувийн хүүгийн түвшинд гаргасан. Хүүг хагас жил тутам төлнө. Өрийн хэрэгслийг гаргаснаас 3 дахь жилийн эцэст хоёрдогч өглөгийг буцаан шилжүүлэх, эсвэл компанийн энгийн хувьцаанд хөрвүүлэх боломжтой. Хөрвүүлэлтийн нөхцөлийг хугацааны эцэст Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.
- 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Rhinos Asset Management Co., Ltd-тэй, 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Rhinos Kai Fintech сантай “Ашгаас хуваалцах 2-р зэргийн хөрвөх бондын гэрээ”-г байгуулан тус бүр 1,000,000,000 won нийт 2,000,000,000 won-ы компанийн энгийн хувьцаанд хөрвөх боломжтой өрийн хэрэгслийг 10 хувь (татварын дараах)-ийн хүүгийн түвшинд 5 жилийн хугацаатай гаргасан. Хүүг жил тутам төлнө. Өрийн хэрэгслийг хугацааны дундуур, эсвэл хугацааны эцэст хэсэглэн болон нийт дүнгээр буцаан шилжүүлэх, компанийн энгийн хувьцаанд хөрвүүлэх, мөн гуравдагч талд шилжүүлэх боломжтой. Хөрвүүлэх үеийн бондын үндсэн үнийн дүнг хөрвүүлэлтийн үнэ /Гэрээ байгуулах үед хөрвүүлснээр гаргах хувьцааны үнэ 150 төгрөг/-д хувааж, хувьцааг бүхэл тоонд шилжүүлэн гаргана. Өрийн хэрэгслийг гаргаснаас 5 дахь жилийн эцэст хоёрдогч өглөгийг хэсэгчлэн болон нийт дүнгээр буцаан шилжүүлээгүй, эсвэл компанийн энгийн хувьцаанд хөрвүүлээгүй тохиолдолд хугацаа автоматаар дахин 5 жилээр сунгагдана.

Эдгээр санхүүгийн хэрэглүүрүүд нь тодорхой нөхцөл бүрдсэн үед энгийн хувьцаанд хөрвөх боломжтой бөгөөд энэ нь компанийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх урт хугацааны бодлогыг илэрхийлж байна.

“СЭНДЛИ ББСБ” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жил

Нийлмэл санхүүгийн хэрэглүүрийг өр төлбөрийн бүрэлдэхүүн болон өмчийн бүрэлдэхүүн хэсгээр тус тусад нь толилуулна. Өрийн бүрэлдэхүүн хэсэг болон хөрвөх эрх бүхий өмчийн бүрэлдэхүүн хэсгийн үнэ цэнийг энэхүү хэрэглүүрийг гаргасан өдөрт нь тодорхойлсон.

Өрийн бүрэлдэхүүн хэсгийн бодит үнэ цэнийг ижил төстэй хэрэглүүрийн зах зээлийн хүүг ашиглан тооцоолсон. Үр ашигт хүүгийн хэмжээ нь 13.6%-аас 15.0% байна.

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Өр төлбөрийн бүрэлдэхүүн	10,980,038,247	-
Өмчийн бүрэлдэхүүн	610,818,992	-
Дүн	11,590,857,239	-

2025 оны жилийн эцсийн байдлаар дараах санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрүүдийг эзэмшиж байна.

6.9. ТОДРУУЛГА-БАРАА МАТЕРИАЛ

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Хангамжийн материал, БҮТЭЗ	236,865,841	117,752,800
Бараа материалын цэвэр дүн	236,865,841	117,752,800
Үүнээс:		
<i>Цэвэр боломжит үнэ цэнээр илэрхийлэгдсэн бараа</i>		

Тайлант хугацаанд бараа материалыг түүний цэвэр боломжит үнэ цэн хүртэл бууруулсантай холбоотой хүлээн зөвшөөрч бүртгэсэн аливаа гарз байхгүй.

6.10. ТОДРУУЛГА-УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Урьдчилж төлсөн зардал	366,964,627	666,681,069
Урьдчилж төлсөн түрээс	27,115,000	19,195,000
Дүн	394,079,627	685,876,069

“СЭНДЛИ ББСБ” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жил

6.11. ТОДРУУЛГА-ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Эхний үлдэгдэл	-	-
Нэмэгдсэн	26,966,710	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө рүү шилжүүлсэн	-	-
Хассан	-	-
Эцсийн үлдэгдэл	26,966,710	-
Хасах: Үнэ цэнийн бууралтын хасагдуулаг	-	-
Цэвэр дүн	26,966,710	-

Өмчлөх бусад хөрөнгө нь хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг барагдуулахын тулд Компанийн хурааж авсан хөрөнгүүд юм. Компани ойрын ирээдүйд эдгээр хөрөнгийг худалдан борлуулахаар төлөвлөж байна.

6.12. ТОДРУУЛГА-ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	Тавилга эд хогшил төгрөг	Компьютер дагалдах хэрэгсэл төгрөг	Нийт төгрөг
<u>Анхны өртөг:</u>			
2024.12.31-ээрх үлдэгдэл	366,882,310	152,200,720	519,083,030
Нэмэгдсэн	176,689,485	90,755,975	267,445,460
Хасагдсан	645,806	1,502,900	2,148,706
2025.12.31-ээрх үлдэгдэл	542,925,989	241,453,795	784,379,784
<u>Хуримтлагдсан элэгдэл:</u>			
2024.12.31-ээрх үлдэгдэл	308,833,358	28,496,797	337,330,155
Нэмж байгуулсан	78,616,127	15,758,478	94,374,605
Хасагдсан хөрөнгийн элэгдэл	100,000	10,846	110,846
2025.12.31-ээрх үлдэгдэл	387,349,485	44,244,429	431,593,914
<u>Хуримтлагдсан үнийн бууралт:</u>			
2024.12.31-ээрх үлдэгдэл	-	-	-
2025.12.31-ээрх үлдэгдэл	-	-	-
<u>Үлдэгдэл өртөг:</u>			
2024.12.31-ээрх үлдэгдэл	58,048,952	123,703,923	181,752,875
2025.12.31-ээрх үлдэгдэл	155,576,504	197,209,366	352,785,870

Тайлант хугацааны эцсийн байдлаар үндсэн хөрөнгөд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн нийт 271,591 мянган төгрөгийн 183 хөрөнгө бүртгэлтэй. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөтэй холбоотой 94,364 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг ашиг, алдагдалд илэрхийлсэн.

Тайлант хугацааны эцсийн байдлаар үндсэн хөрөнгийн бүрэлдэхүүнд зээлийн барьцаанд байршуулсан хөрөнгө байхгүй.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, хорогдуулгын арга болон үлдэх өртөгтэй холбоотой аливаа тооцооллын өөрчлөлт гараагүй.

“СЭНДЛИ ББСБ” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жил

6.13. ТОДРУУЛГА-БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	Программ хангамж төгрөг
<u>Анхны өртөг:</u>	
2024.12.31-ээрх үлдэгдэл	661,607,670
Худалдаж авсан	184,000,000
Данснаас хассан	-
2025.12.31-ээрх үлдэгдэл	845,607,670
<u>Хуримтлагдсан хорогдол:</u>	
2024.12.31-ээрх үлдэгдэл	107,039,565
Нэмж байгуулсан	76,317,479
Хасагдсан хөрөнгийн хорогдол	-
2025.12.31-ээрх үлдэгдэл	183,357,044
<u>Үлдэгдэл өртөг:</u>	
2024.12.31-ээрх үлдэгдэл	554,568,105
2025.12.31-ээрх үлдэгдэл	662,250,626

Тайлант хугацаанд биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа, хорогдуулгын арга болон үлдэх өртөгтэй холбоотой аливаа тооцооллын өөрчлөлт гараагүй.

Тайлант хугацаанд биет бус хөрөнгөтэй холбоотой 76,317 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг ашиг, алдагдалд илэрхийлсэн.

6.14. ТОДРУУЛГА-ТАТВАР ШИМТГЭЛИЙН ӨР ТӨЛБӨР

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
<u>Татвар, шимтгэлийн өглөг:</u>		
ААНОАТ-ын өглөг	882,167,954	854,502,029
Бусад татварын өглөг	719,420,753	221,799,718
Дүн	1,601,588,707	1,076,301,747

6.15. ТОДРУУЛГА-ТҮРЭЭСИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨР

6.15.1. Ашиглах эрх бүхий хөрөнгө

Үзүүлэлт	Барилга байгууламж төгрөг
<u>Анхны өртөг:</u>	
2024.12.31-ээрх үлдэгдэл	204,753,174
Нэмэгдсэн	290,264,990
Хасагдсан	204,753,174
2025.12.31-ээрх үлдэгдэл	290,264,990
<u>Хуримтлагдсан элэгдэл:</u>	
2024.12.31-ээрх үлдэгдэл	182,002,821
Нэмэгдсэн	83,082,341
Хасагдсан	204,753,174
2025.12.31-ээрх үлдэгдэл	60,331,988
<u>Үлдэгдэл өртөг:</u>	
2024.12.31-ээрх үлдэгдэл	22,750,353
2025.12.31-ээрх үлдэгдэл	229,933,002

Компани нь Улаанбаатар хот болон орон нутагт оффисын байр түрээслэн салбарын үйл ажиллагаандаа ашигладаг ба түрээсийн гэрээнүүдэд түрээсийн хугацаанд тогтмол төлбөр төлөхөөр заасан. Компанийн удирдлагын зүгээс түрээсүүдийг үргэлжлүүлэх ул үндэслэлтэй хугацааг 34-36 сар гэж тооцоолж тус гэрээнүүдийн хүрээнд үүсэх ашиглах эрх бүхий хөрөнгө, түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Уг түрээсийн гэрээнүүдийн хувьд түрээслүүлэгч болон түрээслэгч талын хүсэлтээр түрээсийг цуцлах сонголт хийх боломжтой бөгөөд үүнд ижил нөхцөл байдал бүхий бусад түрээсийн байршлын тэнцүү төлбөрийн үнэлгээ нөлөөлөх боломжтой юм.

6.15.2. Түрээсийн өр төлбөр

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Эхний үлдэгдэл	29,511,115	106,754,623
Шинээр байгуулсан гэрээний хүрээнд нэмж үүссэн	290,264,990	
Хүүгийн зардал	35,288,536	15,174,252
Түрээсийн тэнцүү төлөлт	111,768,720	92,417,760
Эцсийн үлдэгдэл	243,295,921	29,511,115
Үүнээс:		
<i>Урт хугацаанд төлөгдөх</i>	<i>154,160,734</i>	

Түрээсийн гэрээний нөхцөлийн дагуу түрээсийн тэнцүү төлбөр нь хэрэглээний үнийн индексээс хамаарсан хувьсах төлбөрийг агуулдаггүй.

Түрээсийн өр төлбөрийн анхны хэмжилтийг түрээслэгчийн зээлийн өсөн нэмэгдэх хүүг ашиглан тооцдог.

“СЭНДЛИ ББСБ” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жил

6.16. ТОДРУУЛГА-БУСАД САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨР

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Бусад өглөг	484,094,065	1,123,893,031
Шимтгэлийн өглөг	43,231,850	25,593,602
Дүн	527,325,915	1,149,486,633

6.17. ТОДРУУЛГА-ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ХӨРӨНГӨ/ӨР ТӨЛБӨР

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
<u>Хойшлогдсон татварын хөрөнгө:</u>		
Ханшийн зөрүү		11,821,123
Түрээсийн бүртгэл	3,340,729	
Дүн	3,340,729	11,821,123
<u>Хойшлогдсон татварын өр төлбөр:</u>		
Ханшийн зөрүү	(93,868,729)	
Дүн	(93,868,729)	
Цэвэр дүн	(90,528,000)	11,821,123

6.18. ТОДРУУЛГА-ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Компани нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани юм. Компанийн нийт дүрмийн сан нь нэг бүр нь 50 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 223,570,000 ширхэг энгийн хувьцаа (2024 онд 223,570,000)-аас бүрдэнэ. Энгийн хувьцаа тус бүр нэг саналын эрхтэй бөгөөд ногдол ашиг хуваарилах нь компанийн шийдвэр бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлагдана.

Хувьцаа эзэмшигчийн нэр	2025.12.31		2024.12.31	
	Эзэмшлийн хувь	Хувь нийлүүлсэн хөрөнгө /төгрөг/	Эзэмшлийн хувь	Хувь нийлүүлсэн хөрөнгө /төгрөг/
Монголын финтек групп хаалттай ХК	78.48%	8,772,430,700	56.42%	6,307,085,000
Олон нийт	9.00%	1,006,069,300	31.05%	3,471,415,000
Сэндли Эмплоје ХХК	8.95%	1,000,000,000	8.95%	1,000,000,000
Б.Наранбат	3.58%	400,000,000	3.58%	400,000,000
Дүн	100.00%	11,178,500,000	100.00%	11,178,500,000

6.19. ТОДРУУЛГА-БУСАД ӨМЧ

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
Нийгмийн хөгжлийн сан	19,052,082	12,942,404
Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн нөөц сан	311,022,165	
Хоёрдогч өглөг (өөрийн хөрөнгө)*	610,818,992	
Дүн	940,893,239	12,942,404

*Хоёрдогч өглөгтэй холбоотой дэлгэрэнгүйг Тодруулга 6.8-с харна уу

6.20. ТОДРУУЛГА-ХҮҮГИЙН ЦЭВЭР ОРЛОГО

Үзүүлэлт	2025.12.31 төгрөг	2024.12.31 төгрөг
<i>Хорогдуулсан зээлийн үйлчилгээний орлого</i>		
Харилцагчдад олгосон зээлийн хүүгийн орлого	33,702,242,143	22,489,830,545
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн хүүгийн орлого	121,350,139	48,691,990
Нийт хүүгийн орлого	33,823,592,282	22,538,522,535
